

УЛААН САН ХК

Монгол улс Увс аймаг Баруунтуруун сум

утас 99459730, 88459730

2019 оны 04 дүгээр сарын 30

Баруунтуруун

Хурлын тэмдэглэл

Увс аймгийн Баруунтуруун сумын Улаансан хувьцаат компаний хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2019 оны 04 дугаар сар 30-ны өдрийн 15 цагт тус сумын соёлын төвд болов.

Хуралд: хувьцаа эзэмшигч 6 хүн ажилчид 4 хүн бүгд 10 хүн оролцов. Компанийн 62177 ширхэг хувьцааны тархалт 2019 оны 02 сарын 25-ны өдрийн байдлаар 22 БДК-ийн харьяалалд 277 хүн байгаагаас нийт хувьцааны 35877 ширхэг буюу 57.7% төлөөлөл оролцож комданийн тухай хуулийн 70.5 дахь заалтыг үндэслэн хурлын бүрэлдэхүүнийг зохих бүрэлдэхүүнтэй гэж үзээд хурлыг нээв.

Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлаар:

1. Компаний 2019 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх
2. Компаний тайланд Аудит хийсэн дүнг хэлэлцэх
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
4. Бусад асуудлыг хэлэлцэхээр хуралд оролцсон нийт хувь нийлүүлэгчдэд танилцуулав.

Хурлыг нээж хурлын дарга Б. Ганболд мэдээлэл хийв.

Хурлын дэгийг хэлэлцэж батлав

Б. Ганболд:

Та бүхний энэ өдрийн амрыг эрье.

Манай компаний ТУЗ компаний тухай хуулийн дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хийж байна. Тус хурлын зарыг Өдрийн мэдээ сонины 2019 оны 03 дугаар сарын 22, 28-ны дугаарууд, Увсын өнгө сонины 2019 оны 04 сарын 15-ны өдрийн дугаарт мөн www.uvsiinungu.mn сайтад нийтлэгдэж Увсийн өнгө сонин, Бэгз Батхүү фейсбүүк хуудсанд байрлуулж зарыг түгээсэн.

Увсын Тулгат-Чандмань Баян брокер дилерийн компанид хөрөнгийн бирж ХК-ийн сайт-д хурлын материалыг байрлуулж нийтэд түгээсэн. Алдартулга Аудитийн компаниар тайланд Аудит хийлгэсэн 1999-2000 онд ТЭД Сангаас авсан КАР-1 КАР-2 төслийн зээлийн үлдэгдэл 12592000 төгрөгөөс энэ онд 6147000 төгрөгийн өрийг төлж одоо 6445000 төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байна. Мөн хөрөнгийн бирж ХК-д 6015626 төгрөг огт төлөгдөөгүй байна. Татварын өр увс айман дахь сум дундын шүүхийн 2001 оны 12 сарын 24-ний өдрийн 622 тоот шийдвэрээр үлдэгдэл 2673200 төгрөг төлөх ёстой гэж шийдвэрлэсэний дагуу 2006 оны 10-р сард 2300000 төгрөг төлсөн байтал дахин 2002 оны газрын төлбөр бичигдэж ирсэн. Иймд 19 жил болсон татварын энэ өрний

УЛААН САН ХК

Монгол улс Увс аймаг Баруунтуруун сум

утас 99459730, 88459730

талаар холбогдох газарт нь асуудал хүргүүлнэ. Энэ 2019 оныг компаний өр авлагыг цэгцлэх жил болгох зорилго тавих хэрэгтэй байна. Бид 2007 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд онцгойлон ярилцаж сумын засаг дарга, ЗДТ газарт саналаа хүргүүлж байсан. Нутгийн өөрөө удирдах ёсны тухай хуулинд “Тухайн орон нутагт байгаа үйлдвэр аж ахуйн газар, компани, пүүс, хоршоонд өмчийн харъяалал харгалзахгүйгээр төр захиргааны байгууллага хяналт тавьж өөрийн зүгээс мэргэжлийн албадаа оролцуулах шалгалт хийж тусламж дэмжлэг үзүүлнэ” гэж заасны дагуу энэ онд компаний өр авлагыг барагдуулахад орон нутгийн төр захиргааны байгууллагын тусламж дэмжлэгийг авч ажиллана. Анхаарал тавьсанд баярлалаа.

А. Даваасамбуу – хувьцаа эзэмшигч

- Компаний өр авлагыг барагдуулах жилийн ажилаа эрчимтэй хийх хэрэгтэй. Хурлаас гарах шийдвэрийг дэмжиж ажиллана.

-Компаний өмч хөрөнгө зарж борлуулаад ч гэсэн өрнөөсөө салах хэрэгтэй. Энэ ажилд компаний ТУЗ, гүйцэтгэх удирдлага анхаарах хэрэгтэй байна.

Л. Дүүдээ – хувьцаа эзэмшигч

-компаний ирээдүй тун бүрхэг хандаж байна. Энэ байдлыг сум орон нутгийн төр захиргааны байгууллага тодорхой төлөвлөгөө гарган танилцуулаад дэмжлэг туслалцаа авч өр авлагаа барагдуулах хэрэгтэй байна. Гэснээр санал шүүмжлэл дуусав.

Шийдвэрлэсэн нь:

1. Компаний ТУЗ-ийг сонгосон, компаний тайланг хэлэлцэж баталсан, Аудитын хорооны тайлан дүгнэлтийг хэлэлцэж баталсан 01,02,03,04 тогтолуудыг батлав.

Хурлыг хааж хурлын дарга Б. Ганболд үг хэлэв.

Өнөөдөр та бид нар компаний хувь нийлүүлэгчдийн хурлыг хийж дуусгалаа. Бүх гишүүдийн хурлаас гарсан тогтоолыг ажил хэрэг болгох талаар ТУЗ онцгой анхаарч ажиллана гэдэгт итгэж байна. Хурлын материалыг эмхэтгэж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д хүргүүлнэ. Тус газрууд хурлын материалтай танилцаж үнэлэлт дүгнэлт өгч үүрэг даалгавар ирүүлэх байх. Өгсөн үүрэг даалгаварыг биелүүлэн ажиллана. Хурал хаасныг мэдэгдье.

Хурлыг мөн өдрийн 15 цаг 20 минутад дуусгав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн Ц. Энхцаг

Уншиж танилцсан Хурлын дарга Б. Ганболд